



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- ☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Сангийн яам

Нэгжийн нэр:

Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтэс

Албан тушаалын нэр:

Төсвийн орлогын асуудал хариуцсан мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Дэс түшмэл, ТЗ-7

Ажлын цаг

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Монгол Улсын Сангийн яам, Чингэлтэй дүүрэг, Засгийн газар II байр Д корпус, С.Данзаны гудамж Улаанбаатар 15160

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, Монгол улсын төсвийн орлогын төлөвлөгөө, төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл боловсруулах, тооцоо судалгааг боловсруулах, орлогын төлөвлөлт, хуваарилалт, санхүүжилтийн бодлогын хувилбар боловсруулах, нэгтгэх, хянах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Улсын болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний төсөл боловсруулах, дунд хугацааны төсвийн орлогын хүрээний мэдэгдлийн төсөл боловсруулах, холбогдох тооцоо судалгаа танилцуулгын хамт боловсруулан удирдлагад танилцуулж, Засгийн газар, УИХ-аар хэлэлцүүлэх, батлуулах;
2. Төсвийн орлогын гүйцэтгэлд орлогын нэр төрөл бүрд хяналт тавьж, татварын орлогын сар, улирал, жилийн батлагдсан төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх, татварын өр барагдуулалт хэрэгжилтэд хяналт тавих, зохион байгуулах;
3. Татвараас хөнгөлөх, чөлөөлөх, буцаан олгох, суутган тооцохтой холбоотой бодлогын арга хэмжээний хувилбар боловсруулах;
4. Холбогдох хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл олгож, түүнд хяналт тавих;
5. Удирдлагаас өгсөн бусад үүргийг хэрэгжүүлэх, шаардлагатай мэдээлэл зөвлөгөөгөөр хангах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1. Улсын болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний төслийг орлогын нэр төрөл, аймаг бүрээр хянаж, холбогдох тооцоо, судалгаа тайлбарын хамт удирдлагад танилцуулах;	Улсын төсвийн орлого тооцсон үндэслэл тооцоогоо тодорхой тайлбарласан байх	Г
	1.2. Орон нутгийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой тооцоолол, судалгаа тайлбар бэлтгэх;	Холбогдох тооцоо судалгааг нь хугацаанд нь хийсэн байх	Г
	1.3. Хууль тогтоомжид өөрчлөлт орсонтой холбогдуулан улс, орон нутгийн төсвийн орлогод өөрчлөлт оруулахаар бол улсын батлагдсан төсвийн орлогын төлөвлөгөөнд холбогдох тодотгол хийж, тайлбар танилцуулга бэлтгэх;	Шаардлагатай тохиолдолд төсвийн тодотгол хийх, тайлбар танилцуулгыг бэлтгэх	Г
	1.4. Төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломжийн талаарх тооцоо судалгаа хийн, саналаа дүгнэлтээ яамны удирдлагад танилцуулах;	Төсвийн орлогыг нэмэгдүүлэх талаарх тооцоо судалгааг хийсэн байх	Г
	1.5. Нэгдсэн төсвийн орлогын сар, улирлын хуваарийг орлогын нэр төрөл, татвар төлөгч бүрээр гаргаж, батлуулан хэрэгжилтэд хяналт тавих.	Нэгдсэн төсвийн орлогын сар, улирлын хуваарийг батлуулсан байх	Г
2 дугаар зорилтын хүрээнд	2.1. Хариуцсан төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангахын тулд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;	Төсвийн орлогын төлөвлөгөө жигд ханган биелэгдсэнээр улсын төсвийн тэнцэл төлөвлөсөн хэмжээнд хангагдсан байх	Г
	2.2. Төсвийн орлогын гүйцэтгэлийг тооцоо, судалгааг боловсруулах;	Төсвийн орлогын гүйцэтгэлийн тооцоо судалгааг хийсэн байх	Г
	2.3. Төсвийн сарын орлогын биелэлтэд судалгаа хийж, тайлбар танилцуулга гарган, статистик	Төсвийн сарын орлогын	Г



	мэдээлэлд оруулах;	биелэлтэд холбогдох тооцоо судалгааг хийсэн байх	
	2.4.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, үүнтэй холбоотойгоор НӨАТ-ын буцаан олголт урамшууллын үйл ажиллагааг зохион байгуулах.	НӨАТ-ын буцаан олголт урамшууллын үйл ажиллагааг хугацаанд зохион байгуулсан байх	Г
3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Татвараас хөнгөлөх, чөлөөлөх, буцаан олгохтой холбоотой тооцоолол хийх, хувилбар боловсруулах, Татварын ерөнхий газраас ирүүлсэн НӨАТ-ын суутган тооцооллыг хянаж, баталгаажуулах.	Татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн тооцооллыг цаг тухай бүрд зохих журмын дагуу хийх	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	4.1.Эд мөнгөний хонжворт сугалааны тусгай зөвшөөрлийг шаардлага хангасан хуулийн этгээдэд олгох, цуцлах, сунгах асуудлыг судалж шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах.	Эд мөнгөний хонжворт сугалааны тусгай зөвшөөрлийг шаардлага хангасан хуулийн этгээдэд олгох, цуцлах, сунгах асуудлыг судалж шийдвэрлүүлсэн байх	Г
5 дугаар зорилтын хүрээнд	5.1.Газар хэлтсийн даргыг цаг үеэ олсон шаардлагатай мэдээллээр хангаж түүний ажилд мэргэжил, арга зүй, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх;	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар цаг хугацаандаа биелсэн байх	Г
	5.2.Цаг үеийн шаардлагаар хийгдэх тооцоо судалгааг хугацаанд нь чанартай гаргаж тайлбар танилцуулгын хамт удирдлагад танилцуулах;	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар цаг хугацаандаа биелсэн байх	Г
	5.3.Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдтэй харилцах, мэдээ тайлан гаргаж өгөх;	Олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажилласан байх	Г
	5.4.Хариуцсан ажилтай холбогдон иргэн, аж ахуйн нэгж, аймаг, яам, агентлагуудаас ирсэн өргөдөл гомдол, албан бичиг, хууль тогтоолын төсөлд зохих журмын дагуу хариу өгч байх;	Хууль журмын хүрээнд албан бичигт хугацаанд нь хариу өгсөн байх	Г
	5.5.Орлогын хэлтсийн сар, улирал, жил, хагас жилийн ажлын төлөвлөгөө тайланг цаг хугацаанд нь боловсруулж, нэгтгүүлэхээр хүргүүлэх.	Хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөгөө тайланг хугацаанд нь гаргаж, нэгтгүүлсэн байх.	Т, Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	- Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.
Мэргэжил	- Санхүү /041201/; - Эдийн засаг /0311/; - Нягтлан бодох бүртгэл /041101/; - Эрхзүй /0421/



	- Бизнесийн удирдлага /041301/	
Мэргэшил	- Төрийн албаны мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх	
Туршлага	- Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- Мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй.
	Асуудал шийдвэрлэх	- Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; - Шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах.
	Багаар ажиллах	- Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох.
	Бусад	- Гадаад хэл, мэдээллийн технологийн болон бусад зайлшгүй шаардлагатай ур чадвар.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Байхгүй

Бусад харилцах субъект

- Эрхэлсэн чиглэлээр яамд, ЗГХЭГ, УИХ-ын Тамгын газар
- Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар
- Аймаг орон нутгийн татвар, санхүүгийн албаны ажилтнууд
- Төрийн захиргааны ба төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд
- Аж ахуйн нэгж, байгууллагууд
- Төрийн бус байгууллага
- Иргэд

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

Байгууллагын нэр:

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

.....М.САНЖААДОРЖ

Шийдвэрийн огноо: 22 12 21

2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар: 645

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

САНГИЙН ЯАМ

Шийдвэрийн огноо: 2022.12.30

Дугаар: 5/144

(тамга/тэмдэг)

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ж.ГАНБАТ

2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

